



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах “Хариуцлагатай шуурхай алба” ажиллуулах тухай

XVII жарны “Сүрээр дарагч” хэмээх “Улаан морин” буюу гал морин жилийн Сар шинийн баярын өдрүүдэд иргэд орон нутагт олноор зорчих, айл өрхүүд цахилгаан эрчим хүч болон ахуйн хийн хэрэглээг нэмэгдүүлэх, зам тээврийн хөдөлгөөн эрчимжих, архи согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдэх зэрэгтэй холбогдон иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалах, төрийн болон нийтийн үйлчилгээний тасралтгүй, шуурхай ажиллагааг хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаас ДААЛГАХ нь:

1.Гал түймэр, ахуйн болон зам тээврийн осол, гэмт хэрэг, нийтийн хэв журмын зөрчил гарах эрсдэлийг харгалзан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад тус тус даалгасугай:

1.1.Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнд:

1.1.1.эрчим хүчний үйлдвэрлэл болон цахилгаан, дулааны шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангах;

1.1.2.сэлбэг, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлж, болзошгүй ослын үед ажиллах багийг 24 цагийн бэлэн байдалд ажиллуулах;

1.1.3.баярын өдрүүдэд төлөвлөгөөт засвар, хязгаарлалт хийхийг хориглох.

1.2.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт:

1.2.1.орон сууцны дулаан, цэвэр болон бохир усны шугам сүлжээний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, цахилгаан шатны техникийн аюулгүй байдлыг шалгаж, найдвартай ажиллагааг хангах;

1.2.2.Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран дуудлага, шуурхай засварын үйлчилгээг бүрэн ажиллуулах.

1.3.Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт:

1.3.1.хот хоорондын болон орон нутгийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

0026800001

1.3.2.авто замын зорчих хэсэг, давааны орчим халтиргаа, гулгаа үүсэхээс сэргийлж давс, бодис цацах, цас, мөсийг цэвэрлэх арга хэмжээг авч, тусгай зориулалтын техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

1.3.3.согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох болон хурд хэтрүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрчимжүүлэх;

1.3.4.зам тээврийн осол их гардаг цэгүүдэд нэмэлт пост, эргүүл ажиллуулах;

1.4.Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд:

1.4.1.Яаралтай тусламжийн 103 төв болон дүүргийн эмнэлгүүдийг нэмэлт эмч, түргэн тусламжийн автомашинаар хангах;

1.4.2.хоол хүнсний хордлого, архи согтууруулах ундаатай холбоотой эрсдэлийн талаар иргэдэд эрүүл мэндийн сэрэмжлүүлэг хүргэх.

1.5.Шадар сайд Т.Доржханд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.5.1.хүнсний худалдаа, үйлчилгээний газруудад эрүүл ахуйн болон хадгалалт, хамгаалалтын горимыг мөрдүүлэх, хяналтыг чангатгах;

1.5.2.үнийн зохиомол хөөрөгдөл үүсгэхгүй байх талаар хяналт тавьж ажиллах.

1.6.Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян)-т:

1.6.1.баярын өдрүүдэд гал түймэр, ахуйн осол, цаг агаарын хүндрэлээс үүдсэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах;

1.6.2.гэр хороолол болон эрсдэл өндөр бүсүүдэд гал түймрийн тандалт, эргүүл, хяналтыг нэмэгдүүлэх;

1.6.3.аврах, гал унтраах хүч хэрэгслийн 24 цагийн жижүүрлэлтийг зохион байгуулах;

1.6.4.пийшин, зуух, яндан, цахилгаан халаагуур, ахуйн хийн хэрэглээтэй холбоотой анхааруулга, сэрэмжлүүлгийг иргэдэд тогтмол хүргэх.

1.7.Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд)-т:

1.7.1.орон байрны хулгай, дээрэм болон бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл, хяналтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх;

1.7.2.нийтийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам алдагдахаас урьдчилан сэргийлэх.

2.Албан даалгаварт дурдсан асуудлаар шаардлагатай тоон мэдээллийг Засгийн газрын Их өгөгдөлд суурилсан Хяналтын самбарт бодит цагийн горимд нэгтгэн харуулахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын захирал Б.Наранбаатар нарт даалгасугай.

3.Эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хариуцлагатай шуурхай алба”-ыг байгуулж, нэгдсэн удирдлага, мэдээллийн урсгалыг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Албан даалгаврын хэрэгжилтийг 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, аюул, осол, онцгой нөхцөл байдлын мэдээллийг Засгийн газрын Шуурхай албанд 2 цаг тутамд хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Б.ЗАНДАНШАТАР